



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Концессын тухай хуулийн хэрэгжилт



Концессын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Улаанбаатар хот
2015 он

<u>Аудитын тайлан</u> <u>бэлтгэсэн:</u>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт	3-4
Нийцлийн аудитын газар	Бүлэг-1: Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн болон концессыг хэрэгжүүлэх орчин бүрдсэн эсэх талаар	5-8
Газрын дарга: Б. Алтанзул	1.1. Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох ажил бүрэн хийгдээгүй, хуулийн зарим заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна	5-6
Аудитын менежер: З.Ариунзаяа	1.2. Хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн зардал ашгийн тооцоо, судалгаа хийгээгүй байна	6-7
Ахлах шинжээч: Я.Наранцэцэг	1.3. Улсын хэмжээнд концессын талаарх нэгдсэн бүртгэлгүй, цахим мэдээллийн сан үүсгээгүй байна	7-8
Аудитор: Д.Дорждулам	Бүлэг-2: Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох, уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн талаар	9-14
2015 оны 2 дугаар сар	2.1. “Уралдаант шалгаруулалтын нарийвчилсан журам, жишиг баримт бичиг, санал, үнэлэх журам”-ын дагуу шалгаруулалтыг явуулж байна	9-14
Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: www.audit.mn	Бүлэг-3: Концессын гэрээгээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар	15-22
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729 дугаарын утас, 260949 дугаарын факсаар харилцана уу.	3.1. Улсын хэмжээнд 7 төсөл хөтөлбөр хэрэгжиж байна	15-20
Хаяг: Үндэсний аудитын газар	3.2. Нийслэлд концессын гэрээгээр хэрэгжиж буй 3 төсөл арга хэмжээний зарим ажил нь хугацаандаа хийгдээгүй байна	20-22
Чингэлтэй дүүрэг, Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3 Улаанбаатар-15160 Монгол Улс	Дүгнэлт	23
	Зөвлөмж	24
	Монгол Улсын Ерөнхий аудиторовн тушаал	25

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
НИТХТ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгч
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ЗАА	Захирагчийн ажлын алба
ТӨХ	Төрийн өмчийн хороо
СТСХ	Стратеги төлөвлөлт, статистикийн хэлтэс
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НАЗГ	Нийслэлийн Авто замын газар
НӨХГ	Нийслэлийн өмчийн харилцааны газар
НЭЗХГ	Нийслэлийн Эдийн засаг хөгжлийн газар
НЗТХ	Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн
НЕТГ	Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар
ТХХТ	Төр хувийн хэвшлийн түншлэл
ТӨХ	Төрийн өмчийн хороо
КТХ	Концессын тухай хууль
УШЖ	Уралдаант шалгаруулалтын журам
КОУШ	Концесс олгох уралдаант шалгаруулалт
ТБОНӨБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТТХ	Төсвийн тухай хууль
СЭЗ	Санхүү, Эдийн Засаг
СБД	Сүхбаатар дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
НЭЗХГ	Нийслэлийн эдийн засгийн хөрөнгө оруулалтийн газар
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудитыг хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2014 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд нийцлийн аудит хийлээ

Аудитын зорилт: Концессын тухай хуулийн хэрэгжилт, үр дүнд аудит хийж дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтын хүрээнд дараах асуудлуудад аудит хийлээ. Үүнд:

- 1.1. Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн болон концессыг хэрэгжүүлэх орчин бүрдсэн эсэх;
- 1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах үйл ажиллагааг хуулийн дагуу хэрэгжүүлсэн эсэх;
- 1.3. Концессын гэрээгээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт хуулийн дагуу явагдаж байгаа эсэх;

Аудитын хамрах хүрээ: Концесс хэрэгжүүлэгч ЭЗХЯ болон орон нутгийн засаг захиргааны нэгж, төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага хамрагдав.

Аудитын арга зүй: Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, концесс олгохтой холбогдсон бичиг баримт, материалыг судлах, үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийж аудитын хөтөлбөрийн дагуу аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмжийг боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, заавар журмыг шалгуур болгон ашиглав. Үүнд:

1. Монгол улсын үндсэн хууль
2. Төрийн аудитын тухай хууль,
3. Иргэний хууль,
4. Концессын тухай хууль,
5. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль,
7. УИХ, ЗГ-ын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТӨХ-ноос гаргасан заавар журам,
8. НИТХ-ын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамжууд, холбогдох бусад хууль тогтоомж, заавар журам.

Аудитын тайлангийн төслийг санал авахаар Засгийн газарт хүргүүлсэн боловч санал ирээгүй болно.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг хөхүүлэн дэмжих замаар МУ-ын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болох зорилгоор УИХ-аас 2009 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, 2010 онд Концессын тухай хуулийг баталжээ.

Концессын тухай хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг концессын гэрээгээр хөрөнгө оруулагчид олгох уралдаант шалгаруулалт явуулах, концессын гэрээ, түүнийг байгуулах, өөрчлөх, дуусгавар болгох, маргаан хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахаар хуульчлагдсан.

Концессыг дор дурдсан төрлөөр гэрээ хийхээр хуульчилсныг дурьдвал:

- Барих-ашиглах-шилжүүлэх,
- Барих-шилжүүлэх, барих-өмчлөх-ашиглах,
- Барих-өмчлөх-ашиглах-шилжүүлэх,
- Барих-түрээслэх-шилжүүлэх
- Зураг төсөл боловсруулах-барих-санхүүжүүлэх-ашиглах
- Шинэчлэн сайжруулах-ашиглах-шилжүүлэх

Концессын тухай хууль хэрэгжиж эхэлснээр МУ-ын Засгийн газар 2010 оны 198 дугаар тогтоолоор Төрийн өмчийн концессын зүйлийн 123 төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг баталсан байна.

2012 онд концессийн чиг үүрэг, ТӨХ-оос ЭЗХЯ-нд шилжсэнтэй холбогдуулан Засгийн газар дээрх тогтоолыг хүчингүй болгож 2013 оны 317 дугаар тогтоолоор концессын зүйлийн 51 төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр шинэчлэн баталжээ.

БҮЛЭГ 1. ТӨР ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДЭМЖСЭН ЭРХ ЗҮЙН БОЛОН КОНЦЕССЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРЧИН БҮРДСЭН ЭСЭХ ТАЛААР

1.1.Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бий болгох ажил бүрэн хийгдээгүй, хуулийн зарим заалтуудыг хэрэгжүүлж ажиллахгүй байна

ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигт эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр Концессын тухай хуулийг батлах, бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хувийн хэвшлийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн байдалд мониторинг, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах зэрэг ажлыг зохион байгуулахаар тусгасан байна.

Энэ ажлын хүрээнд Концессын тухай хууль батлагдаж, хуулийг хэрэгжүүлэхээр дараах дүрэм, журмуудыг баталсан байна. Үүнд:

1. Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолоор “Зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал батлах тухай”;
2. Засгийн газрын 2010 оны 198, 2013 оны 317 дугаар тогтоолуудаар “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай”;
3. Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолоор “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам, жишиг баримт бичиг, санал үнэлэх журам батлах тухай”

Дээрх хууль, тогтоомж, журмыг баталснаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин бүрдүүлэх ажил эхэлсэн боловч бодлогын баримт бичигт тусгасан ажлууд дутуу хийгдсэн байна. Тухайлбал:

Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.8-д “концессын гэрээний хэрэгжилтэд үнэлгээ хийх, хяналт тавих”, ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын 6.1.3-т “төрийн тодорхой үйлчилгээг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх хувийн хэвшлийн этгээдийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн байдалд мониторинг, үнэлгээ хийхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журам батлах” гэж заасны дагуу Концессын гэрээнд үнэлгээ хийх, хяналт тавих журам батлагдаагүй байна.

Мөн төрийн ямар чиг үүргийг хувийн хэвслээр гүйцэтгүүлэх, концессын аль төрлийг түлхүү хэрэгжүүлэх, ямар төсөл арга хэмжээг тэргүүлэх ач холбогдолтой гэж үзэх талаар ЭЗХЯ, ТӨХ болон аймаг, нийслэлийн холбогдох газар, албадууд тодорхой судалгаа, дүгнэлт гаргаагүй байна.

Засгийн газар жил бүр Концессын тухай хуулийн хэрэгжилтийн талаар хэлэлцдэггүй, үнэлэлт, дүгнэлт өгдөггүй нь хуулийн 6 дугаар зүйлийн 1.3¹-т заалтыг мөрдөж ажиллахгүй байна.

Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 2.7-д “Концесс олгох, хэрэгжүүлэх талаар холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх”, 6.3-т “концессын талаар орон нутгийн холбогдох байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлнэ” гэж тус тус заасныг ЭЗХЯ болон орон нутгийн удирдлагууд биелүүлж ажиллаагүй байна.

Монгол улсад Концессын тухай хууль нь хэрэгжээд удаагүй, энэ талаарх ойлголт шинэ, мэргэшсэн мэргэжилтэн цөөн, төсөл хариуцсан албан хаагчид нь концессын төслөө батлуулах, уралдаант шалгаруулалт зохион байгуулах, хэлэлцээ хийх, гэрээг батлуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг бүх асуудлыг хариуцан ажиллаж байгаа нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлсөн байна.

1.2. Концессоор хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн судалгаагүй, төлөвлөлтийн нэгдсэн бодлого байхгүй, зардал ашгийн тооцоо, судалгаа хийгээгүй байна.

Концессын төсөл арга хэмжээний тэргүүлэх ач холбогдолоор нь эрэмбэлээгүй, дэд бүтцийн болон нийгмийн салбар дахь төр хувийн хэвшил, төрийн оролцооны суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг дээшлүүлэх талаарх санал, түүнийг дэмжсэн судалгаагүй Концессын зүйлийн жагсаалтыг баталсан нь Концессын тухай хууль болон батлагдсан хөтөлбөрүүд хэрэгжихгүй байх шалтгаан болжээ.

Энэ нь Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.5-д “Концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь концессын зүйлийн талаар судалгаа хийх, санал боловсруулах”, 7 дугаар зүйлийн 1.2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн өмчийн концессын зүйлийн талаар судалгаа хийх санал боловсруулах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Төрийн өмчийн хороо болон Эдийн засгийн хөгжлийн яам Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4-т “Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1-д заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаар энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ” гэж заасныг зөрчин зардал, ашгийн тооцоогүй санал боловсруулан Засгийн газраар батлуулсан байна. Тухайлбал:

- Төрийн өмчийн хороо 2010 оноос 2012 онд төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлуулахдаа санал, судалгаа авсан талаар баримт байхгүй, жагсаалтыг батлуулахаар Засгийн газарт санал оруулж батлуулсан байна.
- Эдийн засгийн хөгжлийн яам 2012 онд ТХХТ-ийн хүрээнд концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг батлуулах бэлтгэл ажлын хүрээнд 15 яаманд саналаа ТЭЗҮ-ийн хамт ирүүлэхийг албан бичгээр хүргүүлсэн ч 9 яам, нийслэлийн

¹ концессын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд жил бүр мэдээлэх;

Засаг даргаас зардал ашгийн тооцоо, судалгаагүйгээр жагсаалт хэлбэрээр санал ирүүлжээ.

Мөн Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6²-д зааснаар аймаг, нийслэлийн Засаг дарга нь концессын зүйлийн талаарх санал боловсруулахдаа судалгаа хийж, зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлэх тухай заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- *Дархан-Уул, Өмнөговь, Булган аймгууд орон нутгийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлуулахдаа зардал ашгийн тооцоо хийгээгүй;*
- *Нийслэлд 2010-2013 онд концессын зүйлийн жагсаалтад батлагдсан 83 төсөл, арга хэмжээнээс 75-д нь зардал ашгийн тооцоо хийгээгүй байна. Үүнээс НИТХ-ын чуулганы болон Байнгын хороодын хуралдааны үеэр Төлөөлөгчдийн саналаар 13 төсөл арга хэмжээг концессын жагсаалтад нэмж батлуулсан нь судалгаа, зардал, ашгийн тооцоогүй;*
- *Мөн 2010-2013 онд концессын зүйлийн жагсаалтыг НИТХ-аар 6 удаа хэлэлцүүлэхдээ Концессын тухай хуулийн 9.7³-д заасныг зөрчин 38 төсөлд холбогдох байгууллагаас санал аваагүй;*

Концессын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 7-д “аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 9.4⁴-т заасны дагуу саналаа Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхээс өмнө тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулалтын болон концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал авна” гэж заасны дагуу Баян-Өлгий, Говь-Алтай, Төв аймгууд орон нутагт хэрэгжүүлэх концессын зүйлийн жагсаалт боловсруулаад санал авахаар ЭЗХЯ-ны концессын хэлтэст хандаж байсан ч хариу хүргүүлээгүй байна.

2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Концессын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 8-д “зардал, ашгийн тооцоо хийх аргачлалыг эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлана” гэж нэмэлт заалт оруулсан боловч ЭЗХЯ-аас тухайн аргачлалыг шинэчлэн батлаагүй, Төрийн өмчийн хорооны 2010 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Зардал, ашгийн тооцоо хийх түр аргачлал”-ыг мөрдөж байна.

1.3. Улсын хэмжээнд концессын талаарх нэгдсэн бүртгэлгүй, цахим мэдээллийн сан үүсгээгүй байна.

Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.9-д “Эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь улсын хэмжээнд, мэдээллийн сан бүрдүүлэх” тухай, 33 дугаар зүйлийн 4-т “Эрх бүхий этгээд уралдаант шалгаруулалттай холбоотой аливаа баримт бичиг материалыг нэгтгэн мэдээллийн сан үүсгэж хадгална” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй. Үүнд:

²9.6. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 10.2-т заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаархи энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа, зардал, ашгийн тооцооны хамт тухайн аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

³Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 9.4-т заасны дагуу саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхээс өмнө тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулалтын болон эдийн засгийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авсан байна.

⁴Төрийн өмчийн концессын зүйлийн хувьд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 10.1-д заасан жагсаалтад оруулах концессын зүйлийн талаарх энэ хуулийн 10.3-т заасны дагуу боловсруулсан саналаа зардал, ашгийн тооцооны хамт эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

Концессын гэрээгээр хэрэгжүүлэх ажлын мэдээллийн сан байхгүйгээс төрийн болон орон нутгийн концессын зүйлийн жагсаалтад 2 төсөл, хөтөлбөр давхардсан байна. Тухайлбал:

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн концессын жагсаалт”-д нийслэлийн өмчийн концессын зүйлийн жагсаалтаар батлагдсан “Хотын үзэсгэлэнгийн экспо танхим барих”, “Улаанбаатар хотын дулаан, эрчим хүчний хэрэглээг хангах дулаан, цахилгааны станц барих” төсөл арга хэмжээнүүд давхардаж батлагдсан байна.

Концессын тухай хуулийн 7 дугаар зүйлд тодорхойлсон “Нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийн хүрээнд концессын талаарх бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлнэ” гэсэн заалтыг концессын зүйлийн жагсаалт батлуулсан Нийслэл, Дархан-Уул, Өмнөговь аймаг мөрдөж ажиллаагүй байна.

Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Концессын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2.6-д заасан “концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх”, 2 дугаар зүйлийн 7-д “концесс олгох, хэрэгжүүлэх талаар холбогдох бусад байгууллагад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Зарим аймагт ЗДТГ-ын хөгжлийн бодлогын хэлтсийн эдийн засаг, стратеги, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн нь концессын асуудал хариуцан ажиллах чиг үүрэгтэй боловч ЭЗХЯ мэдээлэл, арга зүйн удирдлагаар хангах үйл ажиллагаа дутмаг явуулсан, хууль хэрэгжүүлэх мэдлэг чадвараа дээшлүүлэхэд анхаарч ажиллаагүй байна. Тухайлбал:

Тус хуулийн 7 дугаар зүйлд нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг зааж концессын зүйлийн жагсаалтын төслийг бэлтгэж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, концессын зүйлийн жагсаалтыг нийтэд мэдээлэх үүрэгтэй боловч холбогдох байгууллагууд нийтдээ хэрэгжүүлээгүй байна.

**БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙГ
КОНЦЕССЫН ГЭРЭЭГЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ОЛГОХ, УРАЛДААНТ
ШАЛГАРУУЛАЛТ ЯВУУЛАХ, КОНЦЕССЫН ГЭРЭЭ, ТҮҮНИЙГ БАЙГУУЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТАЛААР**

2.1 Концессоор хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг баталсан журмын дагуу сонгон шалгаруулж байна.

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон 51 төсөл хөтөлбөрүүдээс 7 төсөл хөтөлбөрт концессын гэрээ байгуулагдсан байна.

Концессын гэрээ байгуулсан 7 төсөл, хөтөлбөрөөс 4-д нь ЗГ-ын 317 дугаар тогтоолоор шууд гэрээ байгуулсан байна. Үүнд:

- Дарханы төмөрлөгийн үйлдвэр, Хүний хөгжлийн төв цогцолбор, Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц, Тэлмэний ДЦС төслүүдийг шууд гэрээ байгуулсан байна. Эдгээр төслүүдээс Тэлмэний ДЦС төслийн гэрээ байгуулагдсан талаар авч үзвэл:

Засгийн газрын 2011 оны 40, 127⁵ дугаар тогтоолын дагуу Төрийн өмчийн хороо Шинэ Азиа групптэй Могойн голын дулааны цахилгаан станц барих, ашиглах, төрийн өмчид шилжүүлэх анхны концессын гэрээг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг суманд 60 МВт-ын хүчин чадалтай Дулааны цахилгаан станц барихаар 2011 оны 5 дугаар сарын 11-ны өдөр 183.3 сая ам долларын төсөвт өртөгтэйгээр байгуулсан;

Гэрээ хэрэгжүүлэх судалгааны ажлын явцад газрын байршил нь цэвдэг ихтэй, газар хөдлөлтийн хоёр том хагарлын бүсэд хамрагдсан байсны улмаас барилга барихад геотехникийн хүндрэлтэй гэж тогтоосон тул анхны гэрээ хэрэгжээгүй;

2012 онд Концессын тухай хуулийг Эдийн засгийн хөгжлийн яам хариуцан хэрэгжүүлдэг болсонтой холбогдуулан Засгийн газрын 2011 оны 127 дугаар тогтоолын дагуу байгуулсан Могойн голын дулааны цахилгаан станц барих-ашиглах-шилжүүлэх 22 жилийн онцгой эрх олгох концессын гэрээг Засгийн газрын 2013 оны 156⁶ дугаар тогтоолын дагуу Завхан аймгийн Тэлмэн суманд баригдах Дулааны цахилгаан станц барих-ашиглах-шилжүүлэх төслийн концессын гэрээ болгон 2013 оны 6 дугаар сарын 28-ны өдөр “Шинэ азиа групп” ХХК-тай шинэчлэн 183.3 сая ам долларын төсөвт өртөгтэйгээр байгуулсан;

Концессын гэрээг шинэчлэн байгуулах хэлэлцээний явцад концесс эзэмшигч нь дулааны цахилгаан станцын хүчин чадал 2х30 МВт байсныг 2х50 МВт болгон нэмэгдүүлэн, дулааны цахилгаан станц төслийн техник, эдийн засгийн үндэслэлээ Эрчим хүчний салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн 2013 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан байна.

Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн авто зам, Алтанбулаг-УБ-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам, Дулааны 5 дугаар цахилгаан станц барих гэсэн 3 төслүүдэд Концессын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 10-т заасны дагуу уралдаант шалгаруулалт зохион байгуулж гэрээ хийсэн байна. Үүнээс:

⁵ Могойн голын дулааны цахилгаан станц барих, ашиглах, төрийн өмчид шилжүүлэх онцгой эрх олгох концессын гэрээг зохих журмын дагуу байгуулахыг Төрийн өмчийн хороонд зөвшөөрсөн.

⁶ Засгийн газрын 40 дугаар тогтоолоор Тогойн голын нүүрсний уурхайг түшиглэн барих ДЦС-г Завхан аймгийн суманд барьж байгуулахаар тогтсонтой холбоотой нэрийг Тэлмэний ЦСгэж нэрлэх. Хүчин чадлыг 100 МВт болгон нэмсэн.

Засгийн газрын 2010 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах” тухай 198 дугаар тогтоолоор “Алтанбулаг-Улаанбаатар”, “Улаанбаатар-Замын-Үүд” чиглэлийн хурдны авто замын төслийг концессоор барих, ашиглах, шилжүүлэх төрлөөр хэрэгжүүлэхээр заасны дагуу концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2011 оны 8 дугаар сарын 16-ны өдөр зарласан;

Уралдаант шалгаруулалтад “Алтанбулаг-Улаанбаатар” чиглэлийн хурдны авто замын төсөлд “Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” түншлэл шалгарч, харин “Улаанбаатар-Замын-Үүд” чиглэлийн хурдны авто замын төсөлд оролцогч санал ирүүлээгүй;

Концессын тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу “Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” түншлэлтэй концессын гэрээний нөхцлийн талаар хэлэлцээ хийх явцад түншлэл нь “Алтанбулаг-Улаанбаатар”, “Улаанбаатар-Замын-Үүд” чиглэлийн хурдны авто замын төслийг хамтад нь хэрэгжүүлэх боломжтой гэж санал дэвшүүлсэн тул хоёр төслийг нэгтгэн санхүүжүүлэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэж шууд гэрээ байгуулсан байна.

ЭЗХЯ-аас концессын гэрээ байгуулсан төслүүд

№	Концессын нэр	Концессын төрөл	Концесс эзэмшигчийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Концессын гэрээний хүчин төгөлдөр болох хугацаа	Төслийн төсөвт өртөг	Гэрээ хэрэгжих хугацаа	Барьж байгуулах хугацаа	Дагалдах гэрээ байгуулсан эсэх
1	Нарийн сухайт-Шивээ хүрэн чиглэлийн авто зам	Барих-ашиглах-шилжүүлэх	“RDCC” ХХК	2011.10.26	дууссан	88.0 тэрбум төгрөг	17 жил	2 жил	Хэрэгжиж дууссан
2	Тэлмэний ДЦС	Барих-ашиглах-шилжүүлэх	“Шинэ азиа групп” ХХК	2014.03.20	2 сар	183.3 сая ам. доллар	22 жил	2 жил	Байгуулсан
3	Дарханы төмөрлөгийн үйлдвэр	Барих-ашиглах-шилжүүлэх	“Кью Эс Си” ХХК	2014.04.04	9 сар	725.0 сая ам. доллар	30 жил	4 жил	Хугацаа болоогүй
4	Алтанбулаг-УБ-Замын-Үүд чиглэлийн хурдны авто зам	Барих-ашиглах-шилжүүлэх	“Чингис лэнд Девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” ХХК	2014.03.09	18 сар	10.0 тэрбум ам. доллар	30 жил	2 жил	Хугацаа болоогүй
5	Дулааны 5 дугаар цахилгаан станц	Барих-ашиглах-шилжүүлэх	“Фифт комбайнд хийт энд Пауэр плант ХХК	2014.06.20	9 сар	1.2 тэрбум ам. доллар	25 жил	3 жил	Хугацаа болоогүй
6	Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц	Барих-өмчлөх-ашиглах	“Улаанбаатар усан цэнэгт цахилгаан станц” ХХК	2014.04.08	9 сар	1.0 тэрбум юань	23 жил	3 жил	Хугацаа болоогүй
7	Хүний хөгжлийн төв цогцолбор	Барих-ашиглах-шилжүүлэх	Жам Зам Инвестмент ХХК	2014.09.18	2015.03.18	17.0 тэрбум төгрөг	30 жил		

Одоогийн байдлаар концессын гэрээнд гарын үсэг зурах эрх авсан Таван Толгой-Ханбогд-Ханги чиглэлийн 700.0 сая америк долларын төсөвт өртөгтэй 435 км-ын урттай замд 17 жилийн хугацаанд хэрэгжүүлэх төсөл байна

Концессын гэрээгээр хэрэгжих хатуу хучилттай 11 авто зам барих төслийг хэрэгжүүлэх уралдаант шалгаруулалтыг 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр

зарласан ба энэ шалгаруулалтад тэнцсэн оролцогч гараагүйгээс концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.3-т заасны дагуу санал ирүүлсэн доорх аж ахуй нэгжүүдтэй шууд гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж байна.

Концессын жагсаалтаар батлагдсан авто замын төслийн уралдаант шалгаруулалт явуулсан судалгаа

/мян.төг/

д/д	Төслийн нэр	Концессын төрөл	Уралдаант шалгаруулалт зарласан хугацаа	Гэрээ байгуулахаар болсон хуулийн этгээд	Төслийн төсөвт өртөг
1	Тосонцэнгэл-Улиастай 114 км	Барих-шилжүүлэх	2014-04-30	Города выворга	90,789,720.4
2	Баянхонгор-Алтай 129.4 км	барих-шилжүүлэх	2014.04.30	"Бридж констракшн" ХХК	124,410,000.1
3	Алтай-Дарви 263 км	барих-шилжүүлэх	2014.04.30	"Лунзянь роад энд Бридж" ХХК	151,761,286.0
4	Сонгино сум -Хяргас нуур 135.5 км	барих-шилжүүлэх	2014.04.30	"Шинжин шинфа" ХХК	160,993,946.2
5	Дашинчилэн-Орхон гүүрээс Мөрөн-Тариалан 120 км	барих-шилжүүлэх	2014.04.30	"Монтоно холдинг" ХХК	129,324,000.0
6	Хужирт-төвхөн хийд-Улаанцутгалан 90.1 км	барих-шилжүүлэх	2014.04.30	"Монголын хурдны зам" ХХК	180,354,407.3
7	Дашинчилэн-Өгийнуур-Хөшөөт цайдам 30 км	барих-шилжүүлэх	2014.04.30		
8	Чойр--Бор-Өндөр 50 км	барих-шилжүүлэх	2014.04.30		
9	Дашинчилэн-Орхон гүүрээс Мөрөн-Тариалан 112.7 км	барих-шилжүүлэх	2014.04.30	"Города выворга" ХХК	92,914,324.4
10	Тосонцэнгэл 4 замын уулз-вараас Нөмрөг сонгины 167 км	Барих-шилжүүлэх	2014.04.30	"Алтан саятан" ХХК	211,935,886.7

Дээрх төсөл хөтөлбөрөөс Чойр-Бор-Өндөр чиглэлийн 50 км хатуу хучилттай авто зам, Дашинчилэн-Өгийнуурын замаас Хөшөө цайдам чиглэлийн 30 км хатуу хучилттай авто замын зургийн албан даалгаврыг боловсруулж ирүүлэхийг хүссэн албан тоотыг Зам тээврийн яаманд хүргүүлжээ.

Эрчим хүчний 5 төсөл, хөтөлбөрт уралдаант шалгаруулалтыг 2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр зарласан байна. Ажлын хэсэг 2014 оны 10 дугаар сарын 8-ний өдөр уралдаант шалгаруулалтанд оролцсон санал гаргагчаас ирүүлсэн саналыг Концессын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5-д заасны дагуу доорх аж ахуйн нэгжүүдийг гэрээний хэлэлцээр хийх мэдэгдлийг хүргүүлээд байна.Үүнд:

№	Концессын зүйлийн нэр	Концессын төрөл	Хуулийн этгээдийн нэр
1	Багануурын цахилгаан станц төсөл	Барих-ашиглах- шилжүүлэх	China Nuclear Industry 22 nd Cinsruction Co.,Ltd
2	Шивээ-Овоогийн цахилгаан станц төсөл	Барих- өмчлөх- ашиглах-шилжүүлэх	Тэнцсэн оролцогч гараагүй
3	Дундговь аймгийн Сайнцагаан сумын нутаг Тэвшийн говийн цахилгаан станц төсөл	Барих- өмчлөх- ашиглах	Могоул пауэр ХХК

4	Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэл төсөл	Барих-шилжүүлэх	Sanbian Sci-tech ХХК
5	Чандганы цахилгаан станц, Багануур - Өндөрхаан агаарын шугам барих, Өндөрхаан-Чойбалсангийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц төсөл	Барих-өмчлөх-ашиглах/ Барих-шилжүүлэх	Професи Пауэр Женерешн ХХК

Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад орсон 51 төсөл хөтөлбөрүүдээс 7 төсөл хөтөлбөрт концессын гэрээ байгуулагдаж, 8 авто замын төсөл шууд гэрээ байгуулах ажил явагдаж, эрчим хүчний 5 төсөлд аж ахуй нэгжүүдийг гэрээний хэлэлцээнд урих мэдэгдлийг хүргүүлж, жагсаалтад орсон төсөл хөтөлбөрөөс нийт 20 нь одоогийн байдлаар хэрэгжилтийн эхлэл шатанд явагдаж байна.

ЗГ-ын 2012 оны 103 дугаар тогтоол “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-ын дагуу шалгаруулалт явуулж байгаа боловч шалгаруулалтад оролцох саналтай аж ахуй нэгж цөөн байдаг байна.

Учир нь концессоор гэрээ хэрэгжүүлэгч байгууллагууд төрийн зүгээс үзүүлэх дэмжлэгүүд тодорхой бус байдаг, хэрэгжүүлэх явцад үүсэх эрсдэлийг тооцох эрх зүйн орчин бүрхэг, хууль нь өөрөө шинэ буюу хэрэгжүүлж байсан туршлага байхгүй, концессын зүйлийг ашиглуулсны болон үйлчилгээ үзүүлсний төлөө концесс эзэмшигчийн төлбөрийн тооцооллын аргачлал, түүнд хяналт тавих арга хэлбэр тодорхойгүй зэргээс шалтгаалдаг байна.

Нийслэлд концесс олгох уралдаант шалгаруулалтын журмын 5.1.1⁷-д заасны дагуу 2014 оны 9 дүгээр сарын байдлаар концессын гэрээгээр хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа 21 төсөл, арга хэмжээнээс 16⁸-д нь уралдаант шалгаруулалт зарлагдаж, 4 төсөл, хөтөлбөрт уралдаант шалгаруулалт зарлагдаагүй байна.

КОУШ-ын санал үнэлэх журмын 4.3-4.9, 5.1-5.7-д заасны дагуу урьдчилсан болон уралдаант шалгаруулалтын оролцох болон төслийн саналыг ерөнхий шаардлага, санхүүгийн чадавхи, техник, технологийн чадварын үнэлгээгээр тус тус үнэлж дүгнэсэн байна.

Уралдаант шалгаруулалт зарласан 16 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явц

№	Хэрэгжилт	Төсөл, арга хэмжээний тоо
Анхан шат буюу урьдчилсан уралдаант шалгаруулалт зарласан төсөл арга хэмжээ		16
Үүнээс:	Оролцох санал ирээгүй 5, ирсэн боловч шаардлага хангаагүйгээс гүйцэтгэгч шалгараагүй 1 төсөл арга хэмжээ	6
	Хоёрдугаар шат буюу төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт явагдаж байгаа	3
	Хоёрдугаар шат буюу төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт явагдсан	7
	Үүнээс: Гэрээ байгуулах эрх үүссэн боловч гэрээ байгуулаагүй байгаа	1

⁷16 ажлын холбогдох материалыг аудитад хамруулсан үзсэн бөгөөд СБД-ийн ЗДТГ-ын хуучин барилгыг буулгаж оффис үйлчилгээний зориулалттай барилга барих концессын төслийн уралдаант шалгаруулалтын материалыг НЭЗХГ-ын тухайн төсөл хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Энхболд нь гаргаж өгөөгүй тул аудитад хамрагдаагүй болно.

	Гэрээ байгуулсан	6
--	------------------	---

НЭЗХГ 2013 онд 6 төсөл, хөтөлбөрт концесс олгох гэрээ байгуулах эрх үүссэн бөгөөд 2014 оны 3 дугаар сард 1 төсөл, 4 дүгээр сард 2 төсөл, 9 дүгээр сард 3 төсөл, хөтөлбөрийн гэрээг байгуулсан байна.

Нийслэлийн хэмжээнд Концессын гэрээгээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг хүснэгтээр харуулбал:

№	Концессын нэр	Концессын төрөл	Концесс эзэмшигчийн нэр	Гэрээ байгуулсан хугацаа	Концессын гэрээний хугацаа	Дагалдах гэрээ байгуулсан эсэх
1	Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт бага оврын цэвэрлэх байгууламж барих	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	НАБ сан ХХК	2014.03.10	3 сар	НХОГ-тай барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
2	Өлзийт хорооллоос-шувуун фабрик чиглэлийн 9.06 км авто зам	Барих шилжүүлэх	Өндөр буянт холдинг ХХК	2014.04.09	24 сар	НАЗГ-тай ажил үйлчилгээ гүйцэтгэх гэрээг
3	Хан-уул дүүрэгт түргэн тусламжийн салбар пункт барих төсөл	Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх	"Хүрэл ордон"	2014.04.09	9 сар	НХОГ-тай барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээ
4	Хан-Уул дүүргийн Ахмадын сувилалын барилга барих төсөл	"Зураг төсөл боловсруулах-барих-өмчлөх-ашиглах"	"Хангалуун трейд" ХХК	2014.09.19	18 сар	Хугацаа болоогүй
5	Налайх дүүргийн 640 хүүхдийн сургууль барих төсөл	"Зураг төсөл боловсруулах-барих-шилжүүлэх"	"Магнус капитал" ХХК	2014.09.19	9 сар	Хугацаа болоогүй
6	Налайх дүүргийн хүүхдийн хөгжлийн төв барих төсөл	"Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх"	"Цэцэнгэрс" ХХК	2014.09.19	9 сар	Хугацаа болоогүй

НЭЗХГ болон концесс эзэмшигчдийн хооронд байгуулсан дээрх 6 гэрээ нь гэрээний жишиг маягтын дагуу хийгдсэн бөгөөд КТХ-ийн 21 дүгээр зүйлийн 1.1-д заасан 24 төрлийн нөхцлийг тусган хуулийн дагуу хийсэн байна.

2014 онд концессын эрх олгосон 6 төсөл хөтөлбөрөөс 5 нь нийслэлийн төсвөөс санхүүжилтийг буцаан авах, нэг төсөл болох Хан-Уул дүүргийн Ахмадын сувилалын барилга барих төсөл нь ашиглах, өмчлөх замаар ирээдүйд орох орлогоор санхүүжилтийг нөхөх нөхцөлтэй гэрээ байгуулсан байна

Нийслэлийн ЗДТГ-ын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь төслийн санхүүжилтийг 2015 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 3 төсөл хөтөлбөрийн 100 хувь, 1 төслийн 70 хувийн санхүүжилт болох 23,349.1 сая төгрөгийг, 2016 оны төлөвлөгөөнд 1 төслийн 100 хувь, 1 төслийн үлдсэн 30 хувийн санхүүжилт болох 8,950.0 сая төгрөгийг тус тус тусгахаар гэрээнд заасан байна.

Нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх төлөвлөгөөний судалгаа

№	Концессын нэр	/сая төгрөгөөр/			
		2015 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд		2016 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд	
		Төсөвт өртөг /тэрбум.төг/	хувь	Төсөвт өртөг	Хувь
1	Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт бага оврын байгууламж барих	2,242.3	100	-	-

2	Налайх дүүргийн 640 хүүхдийн сургууль барих төсөл	4,075.0	100	-	-
3	Хан-уул дүүрэгт түргэн тусламжийн салбар пункт барих төсөл	2,681.8	100	-	-
4	Өлзийт хорооллоос-Шувуун фабрик чиглэлийн 9.06 км авто зам	14,350.0	70	6,150.0	30
5	Налайх дүүргийн хүүхдийн хөгжлийн төв барих төсөл	-	-	2,800.0	100
Нийт		23,349.1		8,950.0	

БҮЛЭГ 3. КОНЦЕССЫН ГЭРЭЭГЭЭР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

3.1. Улсын хэмжээнд хэрэгжиж буй 7 төсөл, хөтөлбөрөөс 1 нь бүрэн хэрэгжиж бусад нь эхлэх шатанд байна.

3.1.1 Тэлмэний дулааны цахилгаан станц барилга угсралтын ажлаа эхлэхэд бэлэн болсон байна.

Улсын Их Хурлаас 2007 онд баталсан “Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-т туссан зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Монгол Улсын Эрдэс баялаг, Эрчим хүчний сайдын 2009 оны 336 тоот тушаал, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 40, 127, 2013 оны 156 дугаар тогтоолууд батлагдсан байна.

Эдгээр бодлого, шийдвэрийн дагуу Шинэ Азия групп ХХК нь 2009 онд засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эрчим хүчний газартай ДЦС барих тухай Ажил гүйцэтгэх гэрээ, 2011 оны 5 дугаар сарын 11-нд Төрийн өмчийн хороотой Концессын гэрээ, мөн 2013 оны 6 дугаар сарын 28-нд Эдийн засгийн хөгжлийн яамтай энэхүү гэрээгээ шинэчлэн байгуулжээ.

Концессийн гэрээний 1.2-т заасны дагуу төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрлүүдийг бүрэн авч, төслийн Техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулж Эрчим хүчний яамны дэргэдэх салбарын Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байна.

Түүнчлэн Цахилгаан худалдах, худалдан авах гэрээ, Нүүрс ханган нийлүүлэх гэрээ, Газар ашиглах гэрээ, Ус ашиглах гэрээ, Хяналтын гэрээ гэх мэт Концессын гэрээний дагалдах гэрээнүүдийг холбогдох төр, засгийн байгууллага, компанитай хийжээ.

Мөн төслийн эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчийг борлуулах нэмэлт эх үүсвэрүүд бий болгох талаар зохих арга хэмжээ авч Үйлдвэр, хөдөө аж ахуйн яамтай хамтран ажиллаж, энэхүү цахилгаан станцаа түшиглэн Хөнгөн үйлдвэрийн технологийн парк барих төсөл боловсруулж ЗГ-т саналаа оруулсныг 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар дэмжиж “Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг тус компанид олгох тухай 352 тоот тогтоол гаргаж тусгай зөвшөөрлийг олгосон.

Ийнхүү төслийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж барилга угсралтын ажлыг цаг улирлын байдлыг харгалзан 2015 оны 2 дугаар улиралд эхлүүлэх тухай гэрээ хэлцэлийг гүйцэтгэгч компанитай хийсэн байна.

Төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалт, эргэн төлөлт түүнтэй холбоотой хууль эрх зүйн орчны шинжилгээг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллагаар хийлгэсний дараагаар хөрөнгө оруулагчид энэхүү төсөлд хөрөнгө оруулах боломжтой гэдгээ мэдэгджээ.

3.1.2. Уул уурхай, металлургийн цогцолбор байгуулах төслийн хэрэгжилт гэрээнийхээ дагуу явагдаж байна.

УИХ-ын 2010 оны 11 дүгээр тогтоолоор “Төрийн өмчийг 2010-2012 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийг баталсан.

Тус үндсэн чиглэлд “Өмч хувьчлалыг хийхдээ уламжлалт арга, хэлбэрийн зэрэгцээ ТӨХК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжих, нэмэлт хувьцаа гаргаж нийтэд санал болгох, концессын гэрээ байгуулах, төр хувийн түншлэлийн бусад хэлбэрийг ашиглан хувийн хөрөнгө оруулалтыг татах аргыг голлоно” гэж мөн тогтоолын 5.9-д Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг нээлттэй уралдаант шалгаруулалтын аргаар хувьчилахаар тусгасан байна.



Төрийн өмчийн хороо УИХ-ын дээрх тогтоол болон Засгийн газрын “Дарханы төмөрлөгийн үйлдвэр төрийн өмчит хувьцаат компаний талаар авах зарим арга хэмжээний тухай” 2008 оны 153 дугаар тогтоолыг үндэслэж “Кью Эс Си” компанитай 2010 онд “Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах төслийг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ”, 2011 онд байгуулсан “Дэд бүтэц байгуулах төслийг хамтран хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын гэрээ” зэргийг тус тус үндэслэн 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр концессын шууд гэрээг 30 жилийн хугацаатай байгуулжээ.

Хөрөнгө оруулалтын гэрээний хугацаанд “Кью Эс Си” компани нь Дарханы төмөрлөгийн үйлдвэрт 81.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ. Гэрээний хэрэгжилтийн байдлыг авч үзвэл:

- Концесс эзэмшигчээс Концессын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1⁹-д заасны дагуу 60 тэрбум, 2.13¹⁰-т заасны дагуу 31.9 тэрбум төгрөгийг 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр Сангийн яамны Төрийн сан банкны 900000707 дугаар дансанд шилжүүлсэн байна.
- Гэрээний 2.14-т зааснаар концессын зүйл ашигласан, үйлчилгээг хүртсэний төлөөх төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болсоноос хойш 5 дахь жилээс эхлэн төлөхөөр байна.
- “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-ийг өргөтгөн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн дэргэд 1 сая тонн хүчин чадалтай нойтон соронзон үйлдвэрийн

⁹концессын зүйлийг ашигласан, эсхүл үйлчилгээг нь хүртсэний төлөө төлөх бүх төрлийн төлбөр буюу ирээдүйд олох ашиг;

¹⁰Концессын төлбөрийн урьдчилгааг гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс 30 хоногт багтаан шилжүүлнэ.

барилгын ажил дууссан, тоног төхөөрөмжийн угсралт 90 хувьтай байгаа бөгөөд 2014 оны 10 сард бүрэн хүчин чадлаар нь ашиглалтанд оруулахаар ажиллаж байна.

- Хоёр дахь үе шатны буюу шууд ангижруулсан төмрийн үйлдвэр барьж байгуулах, үйлдвэрийн ган хайлах, цувих цехийн хүчин чадлыг нь нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, Дархан-Сэлэнгийн бүс нутагт Уул уурхай металлургийн цогцолбор байгуулах ажлын бэлтгэл ажлуудыг 2014 онд эхлүүлсэн байна.

Тус үйлдвэрт концессын гэрээ байгуулан 700.0 сая ам долларын хөрөнгө оруулалт хийснээр төмрийн баяжуулах үйлдвэр, ангижруулсан төмрийн үйлдвэр барихаас гадна төмөр зам тавьж, үйлдвэрийн техник технологи шинэчлэгдэж, хүчин чадал нь 6 дахин нэмэгдэх боломжтой байна.

3.1.3. Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн “Хатуу хучилттай авто зам” төсөлтэй холбогдож гарах шийдвэрүүд хүлээгдэж байна.

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэрт байрлах Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 88.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 43.2 км урттай, замын хучилтын өргөн нь 12.3 м 3 эгнээ хоёр зорчих хэсэгтэй, нэг нэмэлт зурвастай, цементээр бэхжүүлсэн суурийн зузаан 25 см, цемент бетон хучилтын зузаан 24 см, 1 тэнхлэгт 26 тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай, нийт 6 тэнхлэгт 150 тонн нүүрс тээвэрлэх боломжтой зам ашиглалтад оруулсан байна.

Ашиглалтад оруулсан зам



Энэхүү хүнд даацын хатуу хучилттай авто замыг МАК, Чинхуа-МАК-Нарийнсухайт, Саусоби Сэндс, Терра Энержи, Өсөх зоос, Гоби Коул зэрэг уурхайн олборлосон нүүрсийг тээвэрлэхэд ашиглахаар барьсан байна

Концесс эзэмшигч “RDCC” ХХК нь 2014 оны 10 дугаар сарын 17-нд замыг ашиглалтанд оруулан гэрээнд заасан хугацаандаа барьж, ашиглаж эхлэхэд бэлэн болжээ.

Концессийн гэрээний 1.11-д “концесс эзэмшигч нь авто замыг ашиглалтад хүлээн авснаас хойш гэрээний хугацаанд...эзэмшиж ашиглах, засвар арчлалтыг хариуцах, хөрөнгө оруулалтын зардлаа нөхөх зорилгоор... тээврийн хэрэгслээс авто замын ашигласны төлбөрийг хураах эрхийг эдлэнэ” гэж, гэрээний 1.12-т авто зам ашигласны төлбөр нь нэг тонн нүүрсний тээвэрлэлт тутамд 1500 төгрөг, НӨАТ-тэй дүн 1650 төгрөгийг авахаар тус тус зааж өгчээ.

Одоогийн байдлаар замын төлбөрийн хураамжийг авч эхлээгүй буюу замын хураамжийн эрх зүйн зохицуулалт хийгдээгүй байна. Шийдвэрлэгдээгүй байгаа асуудлыг дурьдвал:

1. Уул уурхайн олборлогч компаниудын хүнд даацын авто машинуудыг хэрхэн уг авто замаар явуулах асуудлыг шийдвэрлээгүй;
2. Уул уурхай, Зам, тээвэр, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас уул уурхайн олборлогч компаниуд тус замыг ашиглах, тээвэр хийх ажлыг зохион байгуулаагүй байна.

Энэ нь гэрээний 2.10-т заасан “Авто замын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь ЗГ-ын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах авто зам, замын байгууламжийг барих, засварлах, тусгай зөвшөөрлийг олгох зэрэг хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээ эдлэж, төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Одоогийн байдлаар Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлээр нүүрсний тээвэр хийж байгаа авто тээврийн хэрэгслүүд нь шороон замаар тээвэрлэсэн хэвээр байна.

Энэ төсөл нь байгаль орчныг хамгаалах, БНХАУ-тай хийх худалдааны эргэлтийг сайжруулах, авто тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, олон улсын транзит тээврийг нэвтрүүлэх гол зорилготой байжээ.

3.1.4. Алтанбулаг-Улаанбаатар-Замын Үүд чиглэлийн хурдны авто замын төслийн гэрээ байгуулагдаад хүчин төгөлдөр болох хугацаа болоогүй, ЗТЯ хурдны замын трассыг баталгаажуулаагүй хүлээгдэж байна

Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317 дугаар тогтоол, “Зөвшөөрөл олгох тухай” 99 дүгээр тогтоол, “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 399 дүгээр тогтоол, Концессын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1.3, 17.2 дахь заалтуудыг үндэслэн “Алтанбулаг-Улаанбаатар”, “Улаанбаатар-Замын-Үүд” чиглэлийн хурдны авто зам төслийг “Чингис лэнд девелопмент групп-Шинэ хөгжлийн зам” түншлэлтэй 2014 оны 3 дугаар сарын 9-ний өдөр концессын шууд гэрээ байгуулсан бөгөөд гэрээ хэрэгжих хугацаа болоогүй байна.

Концесс эзэмшигч нь хурдны авто замын барилга угсралтын ажлыг батлагдсан зураг, төсөл, хуваарийн дагуу гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 2 жилийн дотор хийж гүйцэтгэхээр гэрээнд заажээ.

Гэрээнд концесс эзэмшигч нь хурдны авто замаар зорчих тээврийн хэрэгслийн зам ашигласны төлбөрийн хэмжээг төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоонд үндэслэн боловсруулж Эрх бүхий этгээдэд тавих бөгөөд Эрх бүхий этгээд нь “Авто замын тухай” хуулийн дагуу төлбөрийн хэмжээг баталгаажуулах асуудлыг шийдвэрлэж өгөхөөр заасан байна.

Аудитаар төслийн гэрээний хэрэгжилтийн зарим байдлыг авч үзэхэд гэрээний 1.7.1 заалт болох Алтанбулаг-Улаанбаатар-Замын-үүд чиглэлийн хурдны авто замын трасс батлах, трассын дагуух газар олгох асуудлыг шийдвэрлэх зэрэг ажил хийгдээгүй байна. Тухайлбал:

1. Зам тээврийн яам хурдны замын трассыг эцэслэн баталгаажуулаагүйн улмаас ажлын зураг хийх, трассын дагуу газар олгох асуудал зэргээс шалтгаалан ажлын нарийвчилсан зураг гаргаж чадахгүй, зам барилгын ажлыг барих гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах ажил удааширсан;
2. Холбогдох тусгай зөвшөөрлүүд хүлээгдэж байна.

Концесс эзэмшигчийн хувьд гэрээний 1.7.2-т заасны дагуу “төслийн хувьцаа эзэмшигчтэй гэрээ байгуулах, төслийн санхүүжилтийн гэрээ хийх, санхүүжилтийг урьдчилан байршуулах, ТЭЗҮ хийх” зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна

Тус хувьцаа эзэмшигч нь төслийн санхүүжилтад шаардагдах 10.0-12.0 тэрбум ам.долларын гэрээ байгуулагдсан гэх боловч хаанаас санхүүжилт авч байгааг санхүүжүүлэгч талтай нууцлах гэрээ хийгдсэн гэсний улмаас хөрөнгө оруулагч талыг нууцалж байлаа.

Энэ байдал нь Концессийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1-д “Хууль тогтоомж, гэрээнд өөрөөр заагаагүй бол концессын гэрээг Монгол Улсын хуулийн дагуу байгуулж, тайлбарлах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгасан байвал зохино” гэж, мөн зүйлийн 1.6-д “концесс эзэмшигчийн санхүүжилт олох, барьцааны эрх үүсгэх эсэх” гэсэн заалтыг ерөнхий гэрээнд санхүүжилтийн талаар тусгаагүй байна.

Мөн концесс эзэмшигч нь төслийн урьдчилсан 15.0 сая ам долларын өртөг бүхий ТЭЗҮ боловсруулж, ЭЗЯ-д танилцуулж, ЗТЯ-ны ШУТЗ-өөр хэлэлцүүлжээ.

Концессын гэрээ байгуулснаас хойш 30 жилийн хугацаанд үргэлжлэх бөгөөд хугацаа дуусгавар болоход хурдны авто замыг үнэ төлбөргүйгээр төрийн өмчид шилжүүлэх төрөлтэй байна.

3.1.5. Дулааны 5 дугаар цахилгаан станц төслийн гэрээ байгуулагдаад хүчин төгөлдөр болох хугацаа болоогүй байна.

"Дулааны Ү цахилгаан станц" 450 МВт-ын хүчин чадал бүхий зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих- ашиглах - засвар үйлчилгээ хийх - шилжүүлэх нөхцөлтэй концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2011 оноос эхэлсэн байна.

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаан, Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 191 дүгээр тогтоолоор төслийн Концессын гэрээ болон бусад дагалдах гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийхийг зөвшөөрч 2013 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Санамж бичиг байгуулжээ.

2013 оны 9 дүгээр сарын 5-ны өдрөөс Төслийн Концессын гэрээ болон бусад дагалдах гэрээний нөхцөлүүдийн талаарх хэлэлцээг эхлүүлэн Монгол Улсад бүртгэлтэй “Фифт Комбайнд Хийт Энд Пауэр Планта” ХХК-тай 2014 оны 6 дугаар сарын 20-ны өдөр гэрээг байгуулсан байна.

Концессын гэрээний хугацаа 25 жил байхаар тооцсон бөгөөд концесс эзэмшигч нь концессын гэрээ байгуулагдснаас хойш цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ, санхүүжилтийн гэрээ болон бусад дагалдах гэрээнүүдийг

байгуулан, байгаль орчинд нөлөөлөх нөлөөлийн үнэлгээг хийлгэн баталгаажуулж барилга угсралтын ажлыг эхлүүлэхээр тусгасан байна.

Одоогоор цахилгаан эрчим хүч худалдах, худалдан авах гэрээ, дулаан худалдах, худалдан авах гэрээний хэлэлцээг эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна.

3.1.6. “Туул сонгино усны нөөцийн цогцолбор” төслийн гэрээ байгуулагдаад хүчин төгөлдөр болох хугацаа болоогүй байна.

Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын харъяа Төв цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах үйлдвэр болон Төвийн эрчим хүчний системийн цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл-хэрэглээний хоногийн ачааллын горимд тохируулга хийх 100МВт хүчин чадалтай “Улаанбаатар-Усан цэнэгт цахилгаан станц төсөл”-ийг концессын барих-өмчлөх-ашиглах төрлөөр гэрээг “Улаанбаатар усан цахилгаан станц” ХХК-тай байгуулсан байна.

Дээрх гэрээг Засгийн газрын 2010 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 198 дугаар тогтоол, Засгийн газрын 2013 оны “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт батлах тухай” 317, “Зөвшөөрөл олгох тухай” 62, “Концессын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох тухай” 403 дугаар тогтоолыг тус тус үндэслэн байгуулжээ.

Төв цэвэрлэх байгууламжаас гарсан хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах үйлдвэр нь Улаанбаатар хотын төв цэгээс 25 км зайд, Сонгинохайрхан дүүргийн 20 дугаар хорооны нутагт, Залаа толгойн зүүн тал, Сонгины дээд амралтын хойно концессын төслийг хэрэгжүүлэх зорилготой концесс эзэмшигчийн Нийслэлийн газрын албанаас зохион байгуулсан “Төсөл сонгон шалгаруулах дуудлага худалдаа”-аас худалдан авсан 170.000 м2 барилгажих талбайд баригдахаар болсон байна.

Концессын гэрээнд талууд гарын үсэг зурснаар гэрээ байгуулагдсанд тооцогдох бөгөөд гэрээнд гарын үсэг зурагдсан өдрөөс хойш 9 сарын дотор дараах дагалдах гэрээнүүд хийгдэхээр төлөвлөгдсөн байна. Үүнд:

- Ус нийлүүлэх гэрээ;
- Төв цэвэрлэх байгууламжаас заасан үйлдвэрт нийлүүлэх бохир усыг ашиглах хамтын ажиллагааны гэрээ;
- Үйлдвэрээс бусад аж ахуйн нэгжүүдэд нөхөн сэргээлт хийсэн усыг нийлүүлэх гэрээ;

Бусад холбогдох тусгай зөвшөөрлүүдийг концесс эзэмшигчид саадгүй олгосноор гэрээ хүчин төгөлдөр болохоор байгуулагдсан байна.

3.2. Нийслэлд концессын болон дагалдах гэрээ байгуулсан 3 төсөл арга хэмжээний ажил нь хугацаандаа хийгдээгүй байна.

Концессын болон дагалдах гэрээгээ холбогдох байгууллагуудтай байгуулсан 3 төслийн концесс эзэмшигчид зам, барилгын угсралтын ажлаа эхлүүлсэн байна.

Дээрх хэрэгжиж эхэлсэн 3 төслийн барилга, замын ажлын явцтай 2014 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр танилцаж төлөвлөсөн хугацаат ажил, түүний хэрэгжилтийг харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

3.2.1 ХУД-ийн түргэн тусламжийн төвийн салбар пункт /барих-шилжүүлэх/

Концессын гэрээний 1.17.12-д “Эрх бүхий этгээд нь ... инженерийн шугам сүлжээнд холбогдох техникийн нөхцөлийг ... 30 хоногийн дотор гаргаж өгсөн байна” гэж заажээ. Гэтэл “Түргэн тусламжийн төвийн салбар пункт барих” төслийн инженерийн шугам сүлжээний нөхцөл болох халаалтын техникийн нөхцлийг 2014 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн байдлаар НХОГ-аас гаргаж өгөөгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Барилга угсралтын ажлын байдал



3.2.2 Өлзийт хороолол-Шувуун фабрик чиглэлийн авто зам /барих-шилжүүлэх/

Уг авто зам барих ажлын хүрээнд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудаас талбайн цэвэрлэгээ, карьерийн нөхөн сэргээлтийн ажил, ус зайлуулах энгийн байгууламжийн ажил, хиймэл байгууламжийн ажлууд хугацаандаа хийгдсэн, харин харлуулсан суурь байгуулах, хучилтын ажлууд хугацаандаа хийгдээгүй байв.



Хиймэл байгууламж хийгдсэн байдал



Замын суурин ажил хийгдсэн байдал

3.2.3 Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт бага оврын цэвэрлэх байгууламж /барих-шилжүүлэх/

НХОГ-аас “НАБ сан”, “Чулуутын багш” ХХК-иудын түншлэлтэй байгуулсан гэрээгээр уг цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсвийг 2014 оны 6 дугаар сарын 10-ны өдөр хүлээлгэж өгөх ёстой боловч түншлэлийн компаниуд нь зураг төсвийг хугацаанд нь хүлээлгэн өгөөгүйгээс барилга угсралтын ажил төлөвлөсөн хугацаандаа эхлээгүй байна.

2014 оны 7 дугаар сард зөвхөн гадна бохирын ажлын зураг төсвийг хүлээлгэн өгсөн, барилгын ажлын зураг төсвийн экспертизийн дүгнэлт 9 дүгээр сарын байдлаар гараагүй байна.

Гэтэл Барилгын тухай хуулийн 13.5-д "... зураг төсөлд магадлал хийлгээгүй тохиолдолд барилгын ажил эхлэхийг хориглоно" гэж заасныг зөрчин 2014 оны 8 дугаар сарын 22-ны өдөр НХОГ, Набсан ХХК-ний удирдлагууд хуралдаж суурийн ажлыг эхлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Дискан фильтр ариутгах
төхөөрөмжийн барилга



Биологи цэвэрлэгээний блок



Бохир усны худаг



Төлөвлөгөөнд тусгагдсанаар дээрх цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил дуусч, шалгалт тохируулга хийх ажил эхлэх ёстой боловч тоног төхөөрөмж нийлүүлэгдээгүй, дэд өртөөний барилгын ажил дуусаагүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Холбогдох төрийн байгууллагууд Концессын тухай хуулиар хариуцуулсан концессын үйл ажиллагааг удирдаж, зохион байгуулах, хяналт тавих, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, түүнчлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл боловсруулах, санал авах, эрэмбэлэх, зардал ашгийн тооцоо хийх зэрэг чиг үүргээ биелүүлж ажиллаагүй байна.
2. Засгийн газраас 2 удаа концессын зүйлийн жагсаалтыг баталсан ба одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа жагсаалтад зардал, ашгийн тооцоо, судалгаа хийгдсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.
3. Концессын зүйлийн жагсаалтаар баталсан нийт төсөл арга хэмжээний 7 нь гэрээ байгуулж хэрэгжүүлэх шатанд, 13 нь гэрээ байгуулах шатанд, зарлагдсан 24 төсөл арга хэмжээнд санал ирээгүй байгаагаас үзэхэд концесс эзэмшигчийг сонгох үйл ажиллагаа удаашралтай байна.
4. Хэрэгжиж байгаа 7 гэрээний концесс эзэмшигчийн 4-ийг шууд, 3-ийг уралдаант шалгаруулалтаар сонгосон, 6 гэрээ барих-ашиглах-шилжүүлэх, 1 гэрээ барих-өмчлөх-ашиглах концессын гэрээ байгуулснаар 1 гэрээ бүрэн хэрэгжиж бусад нь эхлэх шатандаа явж байна.
5. Эдгээр гэрээг амжилттай хэрэгжүүлэхэд концессын төрөл, хэлбэр, тухайн салбарын онцлог, гүйцэтгэж байгаа чиг үүрэг, үзүүлж байгаа ажил, үйлчилгээний онцлогийг харгалзсан аргачлал, журам гараагүй, хуульд заасны дагуу төрөөс дэмжлэг үзүүлэх талаар гэрээнд тодорхой зүйл тусгагдаагүй зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Концессын хуулийн хэрэгжилт, үйл ажиллагааг мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах төрийн захиргааны нэгжийг тодорхой болгож, хуулийн шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагуудыг үүрэгжүүлж хариуцлага хяналтыг сайжруулах.
2. Концессын зүйлийн жагсаалтыг салбарын онцлог, эдийн засаг нийгмийн ач холбогдол, концессын төрөл, судалгаа тооцоог үндэслэн дахин хянаж, хуульд заасан шаардлагын дагуу зардал ашгийн тооцоог тусгаж шинэчлэн батлах.
3. Концессын хууль болон ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичигт заасан шаардлагатай журам болон зардал ашгийн тооцоо судалгаа хийх нэгдсэн аргачлал, зааврыг боловсруулж мөрдүүлэх.
4. Концесс эзэмшигчтэй гэрээ байгуулах үйл ажиллагааг үр дүнд хүргэх, гэрээг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг арилгаж, төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авах.



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2015 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5 дахь заалт "Гүйцэтгэлийн шалгалтын журам"-ын 23.2 "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Концессын хуулийн хэрэгжилт-д хийсэн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Монгол Улсын Засгийн газар-т хүргүүлсүгэй.
3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2015 оны 12 дугаар сарын 15-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөсүгэй.
4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар /Б.Алтанзул/ -т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД